

## УЗБЕКИСТАН УЛСТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ХУДАЛДААНЫ САЛБАРТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

З.Мэнд\*

***Abstract:** In the paper the author tries to seek real possibilities how to expand cooperation in some sectors between Mongolia and Uzbekistan. The People's Republic of Uzbekistan gained its independence from former Soviet Union in 1991. It is a presidential rule state, rapidly developing and pursuing a policy of tradition in combination with reforms in its political and economic relations. Moreover, it is a nation with ancient sedentary civilization, history and Islamic religion and could preserve its own language and tradition. As its experiences of development show, Uzbekistan runs an intensive policy in a number of economic sectors as well as develops active foreign relations in the region, on the basis of its national features. Therefore, Mongolia needs to develop and further deepen relations with rapidly developing Uzbekistan that occupies important stance in Central Asia, in my opinion. Mongolia and Uzbekistan have wide opportunities to cooperate in many sectors, sharing their experiences of development, as they are both landlocked and developing countries with longstanding friendly relations and historical and cultural heritages. In particular, on the basis of their shared values of ancient ties and nomadic cultures, two countries are available to cooperate in the field of tourism. Such cooperation could bring much benefits to both sides. Development of tourism sector causes further relations in many other fields.*

***Key words:** Trade and tourism relations between Mongolia and Uzbekistan, stable tourism, trade, historical heritage, eco foods.*

\*\*\*

Төв Азийн Узбекистан улс нь ЗХУ-аас 1991 онд бие даан тусгаар тогтнолоо олсон бөгөөд энэ багагүй хугацаанд эрчимтэй хөгжиж, улс төр, эдийн засгийн харилцаандаа уламжлал шинэчлэлийг хослуулсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж буй ерөнхийлөгчийн засаглалтай улс юм. Эрт эдүгээгийн эртний суурьшмал соёл түүхтэй, хэл заншлаа харьцангуй сайн хадгалсан исламын шашинтай билээ.

Узбекистан нь бүс нутагтаа өөрийн онцлогтоо тулгуурлан олон улсад идэвхитэй харилцаа өрнүүлж байгаа бөгөөд эдийн засгийн олон салбарт эрчимтэй бодлого явуулж буйг хөгжлийн туршлага нь харуулж байгаа юм. Тиймээс Төв Азидаа томоохон байр суурь эзлэх эртний түүхтэй, эрчимтэй хөгжиж буй Узбекистан улстай харилцаагаа цаашид өргөжүүлэн, улам гүнзгийрүүлж хөгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч буй юм.

---

\* ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.

Монгол, Узбекистан нь түүх, соёлын өв уламжлалын хувьд нягт холбоотой, найрсаг харилцаатай, далайд гарцгүй, хөгжиж буй орнуудын хувьд хөгжлийн туршлагаасаа хуваалцаж, олон салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжтой. Тухайлбал, хоёр улс нь эртний түүхэн хэлхээ, нүүдлийн соёлын өлгий нутаг зэрэг ижил төстэй олон үнэт зүйлс дээрээ тулгуурлан аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлбэл аль ч талдаа ашигтай, өгөөжтэй хэмээн үзэж хэрхэн хөгжүүлэх боломжийг эрж хайх явдал чухал ач холбогдолтой юм. Аялал жуулчлалыг нэн тэргүүнд хөгжүүлэх нь бусад олон салбарт харилцааг өргөжүүлэхэд хялбар болох юм.

Миний бие энэхүү өгүүлэлдээ тодорхой зарим салбарт хэрхэн яаж хамтын ажиллагааг өргөжүүлэх бодит боломжийг эрэлхийлэхийг оролдсон болно.

### **1. Узбекистаны хөгжлийн туршлага, онцлог**

Узбекистан Улс 1991 онд бие даан тусгаар тогтнолоо олж, зах зээлийн нийгэмд шилжих хөгжлийн узбек загварыг тодорхойлсны үр дүнд одоо эрчимтэй хөгжиж байна. Улмаар дэлхийн 140 гаруй улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд манай улс дипломат харилцаа тогтоосон эхний тав дахь улс юм.

Монгол улстай 1992 оны 1 дүгээр сарын 25-нд дипломат харилцаа тогтоосон. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНУзбекистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 1993 оны 11 сарын 5-нд, Соёл шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Узбекистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2004 онд 1-р сарын 14 Бээжин хотноо тус тус байгуулсан байдаг.

Узбекистан улс сүүлийн жилүүдэд эдийн засаг, нийгмийн салбарт олон шинэчлэл хийж, илүү нээлттэй болж байна. Монгол, Узбекистан хоёр улс харилцаагаа улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, хүмүүнлэг, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлэх, улмаар олон улс, бүс нутгийн талбарт уялдаа холбоотой хамтран ажиллах бүрэн боломжтой. Мөн хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтын салбар дахь хамтын ажиллагааны боломжуудыг тодорхойлох, бизнесийн хэлхээ холбоог бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг дагаад бусад олон салбарт хамтын ажиллагаа идэвхжих юм. Хоёр улсын худалдааны эргэлт одоогоор бага хэмжээтэй боловч цаашид өсөх магадлал их байгааг төсөөлж болох үндэстэй. Ялангуяа Узбекистаны хөдөө аж ахуйн салбарт тус улсын хөдөлмөрийн насны хүн амын 60% ажилладаг бөгөөд энэ салбарт инновацийг нэвтрүүлж, кластерийг хөгжүүлэхийг чухалчилж байгаа нь хоёр улс харилцах өргөн боломжийг нээж байгаа юм. Нөгөөтэйгүүр нарлаг Узбекистан бол жимсний орон бөгөөд дэлхийн 80 гаруй улсад жимс, жимсгэнэ, төрөл бүрийн хүнсний ногоо экспортолдог. Тиймээс Узбекистаны талаас манай улсад хүнсний эко бүтээгдэхүүн түүн дотор Монголд тариалах ургуулах боломжгүй жимс жимсгэнийг нийлүүлэх боломжтойгоо илэрхийлсэн байдаг.

Төв Азийн орнуудаас Узбекистан нь ШХАБ-ыг эхнээс нь төдийлөн талархан хүлээж аваагүй, Төв Азийн чөлөөт худалдааны бүс байгуулахын эсрэг байдаг бөгөөд харьцангуй сүүлд энэ байгууллагад элсэн орсон. Өөрөөр хэлбэл, ШХАБ-д эдийн засгийн харилцааг нь түлхүү хөгжүүлэх сонирхолтой бусад чиглэлийг нь гол болгодоггүйтэй холбоотой юм. Тухайлбал, Энэтхэг улсыг ШХАБ-ын гишүүн болоход Узбекистан нь Энэтхэг улстай хамтарсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цахилгаан бараа үйлдвэрлэх, үр тариа, ногоо боловсруулах, арьс шир, торго боловсруулах, хамтарч экспортлох, машин буюу тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх, химийн, ургамал хамгаалах зэрэг салбарт хамтын ажиллагааны<sup>2</sup> олон гэрээ байгуулжээ.

Узбекистан нь ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улсын хувьд гол бодлогыг ерөнхийлөгч гаргах ба хуучин ерөнхийлөгч Ислам Каримовын хувьд Хятадын нөлөөнөөс болгоомжилсон бодлого явуулдаг байсан. Шинээр сонгогдсон ерөнхийлөгч Шавкат Мерзиеёвийн Бээжинд хийсэн анхны айлчлалын үеэр 2017 оны 5 сард 20 тэрбум долларын 100 гаруй хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

Бусад хөгжиж буй улсуудын жишгээр Узбекистан нь өндөр хөгжилтэй орнуудын хөгжлийн чиг хандлага, туршлагаас авах тал дээр идэвхийлэн ажиллаж байгаа нь харагддаг. Тухайлбал Узбекистаны ерөнхийлөгч Шавкат Мирзиеёв засгийн эрхэнд гарсны дараа эхлүүлсэн эдийн засгийн иж бүрэн шинэчлэлийн алхам нь дээр өгүүлснийг илэрхийлэх нэгэн жишээ юм. Нэлээд өвөрмөц гэмээр авч хэрэгжүүлсэн алхмууд дотор гадаадын тэр дундаа Герман, Турк, Өмнөд Солонгос зэрэг өндөр хөгжилтэй улсуудаас нарийн мэргэжилтнүүдийг урьж, төрийн томоохон байгууллагуудад болон төрийн өмчит компаний удирдах албан тушаалд<sup>3</sup> тохоон томилж ажиллуулж буй нь онцлог юм.

Азийн хөгжлийн банкнаас 2019 онд гаргасан тайланд тус улсын эдийн засгийн өсөлтийг дүгнэхдээ “Дэд бүтцийн зардал нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, экспорт, хөдөө аж ахуйн өсөлт нь Узбекистаны эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн боловч чанаргүй зээл өсөх, инфляци нэмэгдэх эрсдэлтэй байна” гэжээ. “Азийн хөгжлийн тойм” (ORA)-д дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 2018 онд 5.1 хувь, 2019 онд 5.2 хувь, 2020 онд 5.5 хувь тус тус өснө гэж таамаглажээ. Узбекистан улсын засгийн газар улс орноо хөгжингүй зах зээлийн эдийн засагтай улс болгох зорилгоо биелүүлэх төлөвтэй байна гэж Узбекистан дахь Азийн хөгжлийн банкны байнгын төлөөлөгчийн газрын дарга Синди Мулвичи үзсэн байна. Тэрээр “Иж бүрэн шинэчлэлийн бодлого нь улс орны бизнесийг хөгжүүлэх таатай уур амьсгалыг бүрдүүлж тэгш бус байдлыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлж, урт хугацааны тогтвортой өсөлтөд хүрч чадна”<sup>4</sup> гэжээ.

<sup>2</sup> ШХАБ дахь Монгол Улсын цаашдын оролцоо. УБ.,2017, 49-р талд

<sup>3</sup> Мир, анализ новостей.ru

<sup>4</sup> ADB Asian Development Bank

## **2. Аялал жуулчлалын салбарт хамтрахуй**

Узбекистан нь түүх соёлын үнэт өвөөр арвин болохоор түүндээ тулгуурлан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд ихээхэн анхаардаг. Тухайлбал тус улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх улсын хорооны дарга Азиз Абдухакимов 2018 оны 1 сард хэвлэлийн бага хуралд тайлагнахдаа: 2017 оны байдлаар, аялал жуулчлалын салбарт гарсан ахиц дэвшлийг нэгтгэн дүгнэсэн нь нэлээд сонирхол татаж байна. Тухайлбал, Узбекистанд 7300 гаруй соёлын дурсгалт үнэт өв тэмдэглэгдсэн байх бөгөөд үүнээс археологийн олдвор 4300, эртний уран барилга 2000 гаруй байна. Энэ эртний барилгаас 500-гаад нь жуулчдад үзүүлэхэд бэлэн аж. Эдгээр эртний дурсгалуудын ихэнх нь Самарканд, Бухар зэрэг хотуудад байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагааг цахимжуулсан нь хэрэглэгчдийн цагийг хэмнэсэн үр дүнтэй арга хэмжээ болсон бөгөөд 2017 оны байдлаар нийтийн хоолны салбар болон хүлээн авах буудлын тоог нэмэгдүүлэх чиглэлээр нэмж 450 төсөл<sup>5</sup> хэрэгжүүлсэн аж.

Мөн аялал жуулчлалын төрлүүдийг олшруулж экотуризмыг хөгжүүлж байна. Зочин гийчид аялагчдын тав тухыг хангах, орон нутгийн ард иргэдийн ахуй амьдрал, аж байдалтай илүү ойр танилцах өргөн боломжийг нээж өгөхийн тулд айлд байлгах, гэр амралтын газруудыг байгуулсан байна. Ташкент хотод аялал жуулчлалын хөгжлийн газрыг байгуулжээ. Мөн визний үнийг бууруулж визний олон зүйл шаардлагыг бас хассан нь оновчтой үр дүнгээ өгсөн байна. Ийнхүү



Зураг №1 Тайлбар: Узбекистан түүх соёлын өвөө хадгалж хамгаалан аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн болгон хөгжүүлж байна. Энд 1219 оноос 1500 он хүртэлх түүхийн цаг үеийг хамарсан өөрөөр хэлбэл Их Монголын үеийн соёлын дурсгалаас Доголон Төмөр хааны үеийн өв, дурсгалт цогцолборууд багтаж байдаг.

<sup>5</sup> Газета.uz

Зураг №2. Төмөр хаан Самарканд хотод найрлаж буй нь. 1370-1405 онд хаанчилж байсан.



Эх сурвалж: <https://ru.wikipedia.org/wiki>

аялал жуулчлалын салбарт тусгайлсан бодлогуудыг хэрэгжүүлж чадсаны үр дүнд 2017 оны байдлаар Узбекистан руу аялсан жуулчдын тоо 2.5 саяд хүрсэн 2016 онтой харьцуулахад 44.3 хувиар илүү гэсэн тоон үзүүлэлт гарчээ. Цаашилбал тус улсын аялал жуулчлалын үйлчилгээний экспорт 1.5 тэрбум доллараас давсан нь 2016 онтой харьцуулахад 24% иар өссөн үзүүлэлттэй аж. 2017 оны эцсийн байдлаар тус улсад дахин 101 зочид буудал шинээр үйл ажиллагаа явуулж, 128 шинэ тур операторууд<sup>6</sup> гарч иржээ. 2017 оны байдлаар Узбекистанд 851 зочид буудал, 561 тур операторууд үйл ажиллагаа явуулж буй ажээ. Узбекистанд аялал жуулчлалыг хамтран хөгжүүлэх бас нэгэн таатай боломж бол сэрүүн бүсийн орнуудын өвлийн

<sup>6</sup> Газета.uz

улирал эхэлсэн үед тус улсад дулаан таатай цаг агаар зонхилох бөгөөд жимс, ногоо ид боловсрон гарсан хэвээр байдгаас энд ирэх жуулчдын урсгал үл зогсох ажээ. Мэдээж Узбекистан нь исламын шашинтай улс учраас бусад исламын шашинтай өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудаас жуулчид ирж мөргөх болон сүм хийдтэй нь танилцах зорилго агуулсан байдаг байна. Узбекистан улстай аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит шалтгаан нь манай хоёр улс өнө эртнээс соёл болоод түүхийн нарийн учир шижмээр холбогдсон, түүхийн олон сонирхолтой цаг үеийг туулсан явдал гэж үзэж болно. Узбекистаны Сурхандарья мужид<sup>7</sup> буддизмын үлдэц бүхий дурсгалт газрууд, сүм хийд байх тул Япон, Өмнөд Солонгос, Хятадаас хөрөнгө оруулагчид аль хэдийнэ сонирхож эхэлсэн онцлогтой. Энэ нь манай улсын сонирхол эрх ашигт ч нийцэх бөгөөд хамтрах бас нэг боломжуудын нэг юм. Одоогоор бидэнд мэдэгдэж буй баримтаар бол 1212 оноос эхлэн Монгол нь Сартуул улстай хил бие биедээ дөтөлж ирсэн байх бөгөөд 500 тэмээн хөсөг бүхий монгол худалдаачид, элч төлөөлөгчдийг Сартуул улсын эзэн хааны цэргүүд барьж хороосны улмаас дайн зарлахад хүрч улмаар байлдан эзлэх болсон<sup>8</sup> хэмээн түүх бичлэгт үлдсэн байна.

Чингис хааны явуулж байсан улс төрийн бодлогыг эдүгээ Узбекистанд олон талтай харж үздэг бөгөөд ихэвчлэн социализмын үеийн ЗХУ-ын үзэл сурталчилсан ойлголтоор тайлбарлах явдал давамгайл байх шиг. Тухайлбал Чингис хааны байлдан дагуулалтыг харгис түрэмгийлэгч, эвдлэн сүйтгэгч, олон хүний амь авсан гэдэг бол түүний дараагийн залгамжлагч Монгол хаадуудыг болохоор сэргэн мандуулагч, нэгтгэн захирагч, шинийг санаачлагч, олон хот балгадыг бүтээн байгуулагч гэж эерэг байдлаар үзэж тайлбарладаг байна. Мэдээж бидний түүхийг нарийн судалж үзвэл бүр эртний улбааг ч харж болох боломжтой тул одоо байгаа харилцааг улам идэвхижүүлэх шаардлагатай юм.

Манай улс аялал жуулчлалын салбарт аль 1954 оноос эхлэн анхаарч ирсэн түүхтэй бөгөөд одоогийн “Жуулчин компани” нь хуучнаар Гадаад Худалдааны Яамны дэргэд “Гадаад жуулчдад үйлчлэх товчоо” нэртэйгээр байгуулагдаж улмаар 1956 оны 7 дугаар сард ЗХУ-ын 15 жуулчинг 9 хоног аялуулахаар хүлээн авсан нь анхны зохион байгуулалттай аялал байжээ. Мөн оны 10 дугаар сард социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд Прага хотноо болсон “Социалист орнуудын жуулчдын байгууллагын анхдугаар бага хурал”-д Монголын төлөөлөгчид оролцсон төдийгүй 10 орчим оронтой жуулчин хүлээн авах гэрээг байгуулсан байна.<sup>9</sup>

Улмаар 1991 онд Монгол улс дэлхийн аялал жуулчлалын байгууллагын гишүүн орон болсон бөгөөд 1990 онд “Гадаадын жуулчдыг үйлчлэх газар”-ыг бие даасан Жуулчин нэгтгэл болгож 1991 онд Өмч хувьчлалын комиссын шийдвэрээр Жуулчин хувьцаат компани болгон өөрчилсөн байна. 1995 онд Засгийн газрын тогтоолоор “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд

<sup>7</sup> Мөн тус цахимд буй.

<sup>8</sup> Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ., 1995, 40-р талд.

<sup>9</sup> [http://www.touristinfocenter.mn/news\\_more.aspx?NewsID=2174](http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?NewsID=2174)

баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж байсан. 1999 онд Монгол Улсад Үнэдэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”, 2000 онд УИХ-аас “Аялал жуулчлалын хууль”-ийг батлан гаргаж эрхзүйн орчинг бүрлүүлсэн байдаг. Манайд жуулчдын 92 хувийг ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, Их Британи, БНКаЗУ, Австрали зэрэг орны жуулчид бүрдүүлдэг. Монгол Улсын хувьд 2018 онд анх удаа хагас сая гаруй буюу 529 мянган гадаад жуулчин хүлээн авч, дотоодын эдийн засагт 569 сая ам доллар буюу 1,5 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй 270 орчим тур оператор компани, 460 гаруй зочид буудал, 400 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж 34 мянга орчим ажлын байрыг бий болгосон байна. Манай улсын Засгийн газраас “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүдэд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх замаар “Аялал жуулчлал”-ыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлж, улмаар 2020 он гэхэд Монгол улсад ирэх гадаадын жуулчдын тоог 1 саяд, аялал жуулчлалын салбарын орлогыг 1 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг дэвшүүлсэн.<sup>10</sup> Аялал жуулчлалын салбарт анх удаа 38 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр “Тогтвортой аялал жуулчлал” төслийг хэрэгжүүлэхээр АХБ-тай зээлийн хэлэлцээрийг байгуулсан бөгөөд төслийн хүрээнд Их Эзэн Чингис хааны төрсөн нутаг Хэнтий аймгийн Дадал сумын нутагт Мянганы суут хүн Их эзэн Чингис хаан төслийг 19 сая ам.доллаароор хэрэгжүүлэх ажээ. Энэ нь олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Манай улс аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх гэж байгаа бөгөөд өргөн цар хүрээнд бодлогоо тодорхойлж бүс нутгийн хэмжээнд хамтарч хөгжүүлэх шаардлага гарч ирж буй нөхцөлд Зүүн хойд Ази төдийгүй Төв Азийн улс орнуудтай энэ салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжтой гэж харж байна.

*Хүснэгт №1. Иргэд харилцан зорчих байдал  
/2019 оны 6 дугаар сар/*

	КИРГИЗСТАН УЛС	
	Киргизстан Улс руу зорчсон Монгол иргэд	Монгол Улсад ирсэн Киргизстан иргэд
2016	212	514
2017	292	438
2018	302	541
2019 оны эхний 6 сард	273	314
Байнга оршин суугаа	63 /2019.01.01/	22 /2019.04.15/

<sup>10</sup> <https://newspress.mn/v1/p/news/9698>

*Иргэд харилцан зорчсон байдал*

	УЗБЕКИСТАН УЛС	
	Узбекистан Улс руу зорчсон Монгол иргэд	Монгол Улсад ирсэн Узбекистаны иргэд
2015	122	218
2016	125	264
2017	87	158
2018	105	139
2019 оны эхний 6 сард	95	132
Байнга оршин суугаа	Мэдээлэл байхгүй	32

*Эх сурвалж: ГХЯ-ны Консулын газар.*

Тухайлбал Узбекистан Улс аялал жуулчлалын салбараа мөн эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлж байгаа нь манай хоёр орон энэ салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит боломж аль аль талд буй юм. Монгол бол түүхийн орон. Монголын түүхийг Ази, Европын улс орнуудын соёл, түүхийг холбож байсан даяаршлыг эхлүүлж байсан гэх мэт олон хүчин зүйлүүдийг бодитоор харах боломж нь аялал жуулчлалын салбарт байгаа бөгөөд энэ давуу талуудаа Узбекистантай уялдуулж аялал жуулчлалын салбараа хөгжүүлэх боломж нөөц их байгаа юм. Энэ нь хоёр улс одоо байгаа харилцааныхаа хүрсэн түвшингээ улам ахиулах боломж нээгдэнэ гэсэн үг. Хоёр улсын аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит боломж нь тус бүс нутагт аялал жуулчлал салбарын өсөлт хурдацтай нэмэгдэх таатай нөхцөл бүрэлдэж буй таамаг буй бөгөөд энэхүү таатай нөхцлийг хоёр тал соргоогоор мэдэрч бүс нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь нэн чухал юм.

Дэлхийн аялал жуулчлалын удирдагчдын консулын тайлан мэдээнд дурдсанаар бол Монгол орны аялал жуулчлалын бүтээгдэхүүн нь Ази, Номхон далайн орнуудын аялал жуулчлалтай харьцуулбал, эдийн засгийн хувьд “үнэтэй аялал”-д тооцогдож байна гэсэн үнэлгээ авсан ажээ. Тэгэхээр аялал жуулчлалын салбарын үзүүлэлт хангалтгүй байгаа дотоод хүчин зүйлүүдээ бодлогын хувьд анхаарч илүү уян хатан болгож аялалын зардал үнэ, тарифыг бууруулуулах шаардлагатай юм.

### **3. Худалдааны зарим чиглэлд хамтрах бодит боломж**

Узбекистаны худалдааны талаар өгүүлэхийн тулд экспортын гол нэрийн бүтээгдэхүүний талаар товч авч үзэх шаардлагатай. Үүнд үнэт металлаас алт, эрчим хүч, газрын тосны бүтээгдэхүүн, нэхмэл даавуун эдлэл, хар ба өнгөт металл, хүнсний болон химийн бүтээгдэхүүн орно. 1991-2018 он хүртэлх хугацаанд Узбекистан улсын экспортын бүтцэд томоохон өөрчлөлт гарсан байдаг. Тухайлбал экспортод хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 3.9%- иас 7.7% , химийн бүтээгдэхүүн 2.3%



-иас 6.3%, хар болон өнгөт металлын бүтээгдэхүүн 4.6%-иас 8.2% хүртэл өссөн байна. Харин импортын гол нэрийн бүтээгдэхүүнд машин, тоног төхөөрөмж 42.5 хувь, химийн бүтээгдэхүүн 13.1 хувийг эзэлж байна. Тус улсын гадаад худалдааны эргэлт 33.8 тэрбум доллар болсон байна.


Узбекистан бол жимсний эх орон гэж хэлэхэд хилсдэхгүй. Энэ нь Узбекистан олон орны хэрэглэгчдийн таашаал сонирхлыг аль хэдийнээ татаад гадаад худалдааны зонхилох байр суурийг эзэлсэн байна. Тухайлбал, Узбекистан нь ОХУ-д жимс, хүнсний ногооны нийлүүлэлтийг хоёр гурван хүчин зүйлээр нэмэгдүүлэхээр төлөвлөж буй аж. Узбекистаны Гадаад худалдааны яамны хэвлэлийн албанаас мэдээлэхдээ: Хоёр орны хооронд “ногоон коридор”-ыг байгуулж шинэхэн боловсруулсан жимс, хүнсний ногооны бүтээгдэхүүнийг Оросын зах зээлд урт хугацаанд найдвартай гаргах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг харилцан хийсэн байна.<sup>11</sup> Уг ногоон коридор нь хүнсний худалдааны салбарыг илүү хурдацтай далайцтай хөгжихөд дөхөм болох ажээ. Оросын талаас ч мөн Узбекистантай хүнсний худалдааны салбараа хөгжүүлэх үүднээс ОХУ-ын хөдөө аж ахуйн дэд сайд Сергей Левин “**ногоон коридор**”-ийн хүрээнд 2017 онд Узбекистаны ерөнхийлөгч Мирзиёев ОХУ-д албан ёсны айлчлалын үеэр хийсэн өндөр дээд түвшний хэлэлцээний үеэр 16 тэрбум долларын 55 гэрээ, хэлэлцээрт харилцан гарын үсэг зуржээ. Эдгээр гэрээнд барилга, байгалийн хий, хүнсний ногоо, жимс жимсгэний хангамж зэрэг худалдааны олон салбарууд<sup>12</sup> багтсан байна.

Монгол улсын хүн амын жимс жимсгэний хэрэгцээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд жимс импортлогч Узбекистанаас жимс жимсгэнэ авах нь манай хоёр улсын худалдааны зонхилох чиглэл болох боломж байна гэж үзэж байна.

<sup>11</sup> Tj.sputniknews.ru

<sup>12</sup> <https://tj.sputniknews.ru>

Зураг № 3. 2005-2018 онд Узбекистантай хийсэн гадаад худалдаа, импорт.



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. [www.1212.mn](http://www.1212.mn)

2005 оноос 2018 он хүртэлх Узбекистанаас импортлосон нийт барааны дүнг шугаман график дээр харуулав. Импортын ерөнхий дүр зургийг үзвэл 2012-2015 оны хооронд бага зэрэг өсөлттэй буюу 4.369.9 мян.ам.доллараас 6.175.5 мян. ам.долларын хооронд хэлбэлзэж 2016 оноос 603.55 мян.ам.доллар болж буурч байснаа эргээд 2018 оны байдлаар 1.771.6 мян.ам.доллар болж өсөх хандлага харагдаж буй боловч, нийт дүнгээрээ тогтвортой биш байгаа юм. Энэ нь манай улстай хийж буй импортын хэмжээгээр Төв Азийн орнуудын дотроос Казахстан, Киргизстаны дараа орж байна.

Энд худалдааны олон салбаруудаас хүнсний худалдаа тэр дундаа хатаасан жимс, жимсгэний талаар дэлгэрүүлэн авч үзвэл, Монголын томоохон аж ахуйн нэгжүүд энэ салбарт хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлээд эхэлсэн байна.

Нийтэд түгсэн цахим мэдээллээс үзвэл 2018 онд Монголын томоохон компаниудын нэг болох “Номин Холдинг”-ийн төлөөлөгчид Узбекистанд зочилж олон компаниудын үйл ажиллагаатай танилцаж хэд хэдэн төрлийн аж ахуйн нэгж, компаниудтай хамтран ажиллахаар болсон байна. Үүний нэг нь “Узагроэкспорт” компанитай Номин Холдинг компани 10 сая ам долларын гэрээг амжилттай хийж Узбекистанаас Монгол улс руу хатаасан жимс, жимсгэнэ, хүнсний ногоо импортлох хэлэлцээр байгуулан ажилласан байна. Тус компаниас албан ёсоор мэдээлэл авах хүсэлтээ илэрхийлэн хандахад “Номин тав трейд”-ийн худалдаа, импорт хариуцсан газраас дараах мэдээллийг албан ёсоор авсан юм. Узбекистаны

аж ахуйн нэгж болох “Green Desert” компанитай худалдааны гэрээ байгуулан эдгээр нэр төрлийн жимс жимсгэнийг импортлон<sup>13</sup> дотоодын хүнсний хэрэгцээнд худалдаалж эхэлсэн ажээ. Үүнд хүснэгтэнд зөвхөн жимс, жимсгэний нэр төрөл орсон болно:

Хүснэгт № 2. Хатаасан жимсний нэр төрөл

Нэр	Нэр
Үзэмборкг, Узбекистан,	raisans sultana-abjush-yellow
Үзэмшаркг, Узбекистан,	raisans golden-jombo
Үзэмхаркг, Узбекистан,	raisans black
Хатаасанчангаанзкг, субхон, Узбекистан,	dried apricot-subkhon
Хатаасанчангаанзкг, лимон, Узбекистан,	dried apricot-limon
Хатаасанчангаанзкг, жомбо, Узбекистан,	dried apricot-jombo
Хатаасанинтооркг, ястай, Узбекистан,	cherry-plum with bone
Хатаасанлийркг, ястай, Узбекистан,	pear dried
Хатаасаналимкг, ястай, Узбекистан,	apple dried
Харчавгагк, ясгүйчихэрлэг, Узбекистан,	prunes-balonka*sweet
Харчавгагк, ясгүйчихэрлэгисгэлэн, Узбекистан,	prunes-spain*sweet and sour
Хушганыидээкг, Узбекистан,	walnut light-kenel
Хушгагк, ястайУзбекистан,	walnut shell
Миндалькг, Узбекистан,	almonds peeled-kernel

Эх сурвалж: “Номин Тав Трейд” БҮС-ийн салбар

Тайлбар: Хүснэгт № 1-ийн хувьд тус аж ахуйн нэгжээс тодорхой тоон мэдээлэл албан ёсоор өгөөгүй бөгөөд зөвхөн импортоор оруулж ирсэн хатаасан жимсний нэр төрөл багтсан болно.

Манай хоёр улсын худалдааны салбар харьцангуй эрчимтэй бус байгааг хоёр талын хөрөнгө оруулалтын байдлаас харж болох юм. Дараах хүснэгтэд хөрөнгө оруулалтын байдлыг үзүүлэв. Үүнд:

Хүснэгт № 3. Монгол Улсад бүртгэгдсэн ГШХО-салбараар

Узбекистан

№	Салбарууд	%	Total	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
1	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	46.06	1,001.10					100.0	606.10	295.00		
2	Худалдаа, нийтийн хоол	53.94	1,172.48		3.20				150.00	550.00	269.28	
	НИЙТ ДҮН	100	2,173.57	0.00	3.20	0.00	0.00	100.00	756.10	845.00	269.28	0.00

Эх сурвалж: ГХОГ Үндэсний хөгжлийн газар

<sup>13</sup> Номин Тав Трейд БҮС-ийн салбар. www.nomin.mn

*Хүснэгт № 4. Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай  
компанийн тоо-салбараар*

*Улс: Узбекистан*

№	Салбарууд	%	Total	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
1	Худалдаа, нийтийн хоол	91.67	11		1				2	6	2	
2	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	8.33	1					1				
	НИЙТ ДҮН	100	12	0	1	0	0	1	2	6	2	0

*Эх сурвалж: ГХОГ Үндэсний хөгжлийн газар.*

Тайлбар: 2, 3-аар хүснэгтийн тоон мэдээ нь 1990-2012 оны хооронд Узбекистанаас манай улсад оруулсан хөрөнгө оруулалтын мэдээлэл багтсан бөгөөд 2012 оноос хойш статистик мэдээ гараагүй байгааг үзэхэд хоёр талын харилцаанд хөрөнгө оруулалт орж ирээгүй байгааг илтгэнэ. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээний хувьд авч үзвэл тус улсаас оруулсан хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа юм.

Дээрх хүснэгтээс харахад Узбекистаны хөрөнгө оруулалт болон хоёр талын худалдааны тоо баримт харьцангуй чамлалтай байгаа учир цаашид энэ салбарт Монголын тал эрчимтэй бодлого явуулж илүү хүчин чармайлт гаргах шаардлагатай хэмээн үзэж болно.

## ДҮГНЭЛТ

1. Монгол, Узбекистаны харилцааг улс төрийн төвшинд өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь хоёр улсын соёл, түүхийн гүнзгий холбоотой явж ирсэн эртний харилцааг сэргээж олон салбарт харилцааг өргөжүүлэх үүд хаалга нээх болно. Одоогийн түвшинд хоёр улсын улс төрийн харилцааг шат ахиулах хэрэгцээ байхын сацуу эдийн засаг, худалдааны харилцааг гүнзгийрүүлэх шаардлагатай. Учир нь Төв Азийн бүс нутгийн орнуудын эдийн засгийн интеграци эрчимжиж буй нөхцөлд хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь бүс нутгийн аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэргийлэх нөхцөл бүрдэх юм.
2. Монгол улсын хувьд Төв Азийн улс орнуудтай харилцаагаа сайжруулах олон алхмуудын нэг нь Төв Азидаа жин нөлөө ихтэй, түүх соёлын өнө эртний холбоо харилцаатай явж ирсэн Узбекистан улстай харилцааг олон талаар хөгжүүлэх явдал бөгөөд энэ нь стратегийн чухал ач холбогдолтой юм. Энэ үүднээс ч Төв Азийн бүх улс орнуудтай хамтын ажиллагааг тэгш бодитойгоор өргөжүүлэн хөгжүүлэх зорилт буйг аль ч түвшинд анхаарч ажиллах нь зүй юм.
3. Аялал жуулчлал болон худалдааны салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх нь хоёр улсын аюулгүй байдал болон бүс нутагт их гүрнүүдийн явуулж буй эрчимтэй бодлого, үйл ажиллагааг тэнцвэржүүлэх сайн талтай бөгөөд үйлдвэржилт хэт хурдацтай хөгжиж буй өнөө үед байгаль орчин, хүн ардын ёс заншил, түүх соёлоо хамгаалж үлдэхэд нэн их ач холбогдолтой юм.
4. Хоёр орны хувьд аль аль нь аялал жуулчлалын нөөц боломжоо ашиглаж хөгжих бодлого бармталж буй бөгөөд түүх, соёлын эртний харилцаа, өв санд түшиглэн олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар энэхүү салбарт хамтран ажиллах өргөн боломжтой гэж үзэж байна. Учир нь хоёр орны ард түмэн бие биенээ танихад түүхэн аялал жуулчлал илүү ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хоёр улсын иргэдийн харилцан зорчсон жуулчдын тоог өсгөх боломж нь аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал гэж ойлгож болно.
5. Худалдааны салбарт хоёр талын бизнес уулзалтыг явуулж, цаашлаад уламжлал болгон хамтран зохион байгуулах, хүн амаа эрүүл аюулгүй эко хүнсээр хангах бодлогод нийцүүлэн Узбекистанаас жимс жимсгэний импортыг нэмэгдүүлэх, нөгөө талаас манай улс Узбекистаны зах зээлд мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх зэргээр бие биеэ нөхөх харилцан ашигтай нөхцлөөр худалдаа хийх боломжтой гэж үзэж байна.
6. Төв Азийн улсуудтай харилцаа хамтын ажиллагааг өргөн хүрээнд аль болох олон салбарт хамтарч, жигд тэнцвэртэй болгож худалдаа-эдийн засгийн салбарыг түлхүү хөгжүүлэх нь бусад салбарт амжилт олох үндэс болох бөгөөд зөвхөн аль нэг олон улсын байгууллагаар дамжиж харилцана гэдэг ойлголтоор хандах нь зохисгүй юм. Тухайлбал, манай улс ШХАБ-д гишүүнээр элсэх юм бол Төв Азийн улсуудтай илүү ойр нягт хамтын ажиллагаа, харилцаатай болно

гэдэг үзэл баримтлалаар авч үзэх нь өрөөсгөл болно.

## НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Евроазийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай гэрээ. (БНКаУ-ын Монгол Улсад суугаа ЭСЯ-аас эрхлэн гаргасан). УБ.,2014.
2. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ.,1995.
3. Монгол, ОХУ, БНХАУ-ын хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа. УБ.,2000.
4. Г.Нямдоо. Далайд гарцгүй улсуудын далайд чөлөөтэй гарах, түүний баялгийг эзэмших эрх. УБ., 1986.
5. Г.Пунцагдаш, П. Эрдэнэзаяа. Гаалийн тухай хууль. Цомог, хэлхээ зураг. УБ.,2009.
6. Н.Очирбал. БНМАУ-ын гадаад худалдаа. УБ.,1979.
7. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага дахь Монгол улсын цаашдын оролцоо. УБ.,2017.
8. Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага. (Баримт бичгүүдийн эмхэтгэл) Тагнуулын ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээний газар.УБ.,2011.
9. Шим И Соб, Г.Мөнхнасан. Зүүн хойд Азийн эрин үе ба Монголын эдийн засаг. Сөүл., 2015.

Орос хэлээр:

1. Ю.А. Никитина. ОДКБ и ШОС модель регионазма в сфере безопасности. Москва.,2009.

Цахим ном зүй:

1. <http://www.подробно.uz>
2. <http://www.info@mfa.uz>
3. <http://www.consul@mfa.uz>
4. <http://www.tourism.in.uzbekistan.uz>
5. [www.intracen.org](http://www.intracen.org)
6. [http://www.touristinfocenter.mn/news\\_more.aspx?NewsID=2174](http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?NewsID=2174)
7. <https://oec.world/ru/profile/country/uzb/>